

Шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны тайлан мэдээлэл /2012-2016 он/

- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын чиглэлээр 2 их сургууль эрдэм шинжилгээ судалгааны үндсэн 4 хүрээлэн, үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс дурдвал ХААИС нь өнөөдөр бүрэлдэхүүний 8, орон нутгийн салбар 3 сургууль, харъяа тэргүүлэх 4 эрдэм шинжилгээний хүрээлэн, үйлдвэрлэлийн нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулж, тэдгээрт 1000 гаруй эрдэмтэн багш, эрдэм шинжилгээний ажилтан, ажиллагсад ажиллаж, бакалавр, магистр, докторын шаталсан сургалтанд 10.000 гаруй оюутан суралцаж байгаа эрдэм шинжилгээ-сургалт-үйлдвэрлэлийн гурвалсан холбоо бүхий үндэсний хэмжээний төрийн томоохон ууган их сургуулиудын нэг болно. Манай эрдэмтэн судлаачдын судалгаа шинжилгээний ажлын үр дүнд үр тарианы 96 сорт, төмсний 14 сорт, хүнсний ногооны 39 сорт, жимс жимсгэний 16 сорт тус тус бүтээж шалгаруулсан. Үүнээс гадна төрөл бүрийн таримлуудыг тарималжуулж ургуулах 120 технологийн зөвлөмж боловсруулж үйлдвэрлэлд нэвтрүүлсэн. Судлаачдын боловсруулж баталгаажуулсан үр тарианы сортын 30 хувь, төмсний сортын 100 хувь нь, хүнсний ногооны сортын 60 хувь, жимс, жимсгэний 70 хувь нь Монголд тариалагдаж байна. Мөн түүнчлэн мал аж ахуйн салбарт адууны 1 үүлдэр 3 омог, тэмээний 3 үүлдэр, үхрийн 3 үүлдэр, хонины 22 үүлдэр, ямааны 4 үүлдэр, 5 омог бий болж баталгаажсан байна. Мал эмнэлгийн салбарын эрдэмтэн судлаачдын 4 нээлт Дэлхийн шинжлэх ухаанд бүртгэгдэж, 64 малын эмчилгээний вакцин, оношлуур, 72 эм, био бэлдмэл бий болсон байна. Үр дүнг нь шууд үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломжтой 200 гаруй технологи, бүтээгдэхүүн бэлэн болоод байна.

- Хүнс, хөдөө аж ахуй яамны шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөлийг шинэчлэн байгуулах зорилгоор зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг боловсруулж Сайдын 2015 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А-26 дугаар тушаалаар батлуулсан бөгөөд байнгын үйл ажиллагаа явуулж ирсэн. Тус зөвлөл нь салбарт хэрэгжүүлэх шинжлэх ухаан, технологийн төслийн хүрээнд шийдвэрлүүлэх шаардлагатай асуудлыг тодорхойлон хэлэлцэж төслийн захиалгыг БСШУСЯ-д хүргүүлдэг. Мөн салбарт хэрэгжүүлж дууссан шинжлэх ухаан, технологийн болон цөм технологийн төслийн үр дүнг хэлэлцэн хүлээн авах асуудлыг шийдвэрлэж байна. Түүнчлэн салбарт хэрэгжүүлж буй, хэрэгжүүлж дууссан шинжлэх ухаан, технологийн болон цөм технологийн төслийн явц, үр дүнтэй танилцах “Мониторинг-2014, 2015, 2016” ажлыг жил бүр зохион байгуулсан болно.

- Салбарын шинжлэх ухаан үйлдвэрлэлийн холбоог бэхжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор “Сайдын дэргэдэх эрдэмтдийн зөвлөл байгуулах тухай” тушаалыг боловсруулж Сайдын 2015 оны А-32 дугаар тушаалаар батлуулсан. Тус зөвлөл нь салбарт хэрэгжүүлж буй хууль эрхзүйн баримт бичиг, төсөл, хөтөлбөр, тогтоол, шийдвэрийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр боловсруулахад чиглэл, зөвлөмж, санал өгч ажиллах байнгын үйл ажиллагаатай зөвлөл юм.

- Салбарын эрдэм шинжилгээний ажилтнуудын оюуны бүтээлийг дэмжих зорилгоор “Салбарын судалгаа, хөгжлийн ажилд грант олгох” журмыг Хүнс, хөдөө аж ахуйн Сайдын 2015 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А-80 дугаар тушаалаар батлуулан журмын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Дээрх журмын дагуу бүтээлийн шалгаруулалтыг зохион байгуулж “Судалгааны ажилд грант олгох тухай” Сайдын 2015 оны А-17, А-116 дугаар тушаалуудыг батлуулж 2014, 2015 онуудад тус бүр 2 бүтээлийг шалгаруулж энэ тухай дэлгэрэнгүй мэдээллийг яамны вэб хуудсанд тухай бүр байршуулсан.

- Салбарын хүний нөөцийг бэлтгэх, чадвартай, мэдлэгтэй, мэдрэмжтэй, сэтгэлтэй боловсон хүчнийг хэрхэн яаж бэлтгэх, ахлах ангийн сурагчдыг энэ салбарын боловсон хүчин болох хүсэл тэмүүллийг бий болгох тэдэнд мэдлэг мэдээлэл өгөх чиглэлээр ямар арга хэмжээ зохион байгуулах гэх зэрэг асуудалд салбарын эрдэмтэн, судлаачид, багш нар, бодлого боловсруулагчдын санаа бодлыг сонсох, саналыг тусгах зорилгоор Хөдөө аж ахуйн их сургуультай хамтран “Хөтөлбөрийн шинэчлэл-Хамтын ажиллагаа” сэдэвт зөвлөгөөнийг 2015 оны 04 дүгээр сарын 02,03-ны өдрүүдэд 4 багц чиглэлээр зохион байгуулав.

- Хүнс, хөдөө аж ахуйн салбарыг улс орны эдийн засгийн тулгуур салбар болгоход чиглэгдсэн шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн холбоо-инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх арга зам, үйл ажиллагааг тодорхойлох зорилгоор олон талын оролцоот ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИ, ИННОВАЦИЙН Үндэсний чуулганыг анх удаа 2016 оны 03 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулсан. Энэхүү чуулганд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, үйлдвэрлэгчид, эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургуулиудын нийт 260 гаруй төлөөлөл оролцсон. Чуулган зохион байгуулах ажлын хүрээнд чуулганы нэгдсэн хуралдаан, инновацийн бүтээгдэхүүний үзэсгэлэн зохион байгуулагдаж, 500 гаруй шинэ бүтээгдэхүүний мэдээлэл агуулсан эмхэтгэл ном, 20 минутын видео нэвтрүүлэг хийгдсэн болно.

- Хүнс, хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх инновацийн хөтөлбөрийг боловсруулан Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2016 оны А-43 дугаар тушаалаар батлуулж, хэвлүүлэн нийтлүүлсэн.

Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ

- Хөдөө аж ахуйн зөвлөх нэвтрүүлэх үйлчилгээний тухай /экстэйншны/ хууль эрхзүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр хуулийн төсөл боловсруулах, ажлын хэсэг байгуулах.
- Салбарын судалгаа ба хөгжлийн тогтолцоог шинэчлэн бүрдүүлэхэд олон талын оролцоог нэмэгдүүлэх, дэмжлэг үзүүлэх.
- Судалгаа ба хөгжлийн ажлын үр дүнг зах зээлийн эргэлтэд оруулах чиглэлээр инновацийн зуучлал, мэдээлэл, маркетингийн тогтолцоог хөгжүүлэх, талуудын оролцоог хангах.
- Инкубатор, загвар аж ахуй, агро парк байгуулахад дэмжлэг үзүүлэх.
- Шинжлэх ухаан, технологийн болон инновацийн төслүүдийг хэрэгжүүлж, үр дүнгийн талаар үйлдвэрлэгч олон нийтэд мэдээлэл хүргэх, бүтээлүүдийн үр дүнгийн нэгдсэн сан бүрдүүлэх.
- Оюуны багтаамж өндөртэй, экспортын чиг баримжаатай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ, үйл ажиллагаа зохион байгуулах.
- Шим, тэжээллэг болон органик хүнсний нэр төрлийг нэмэгдүүлж, үйлдвэрлэлийг хөгжүүлэх ба судалгааны дүнд суурилан зохицуулах үйлчилгээтэй хүнсийг үйлдвэрлэлд туршин нэвтрүүлэх.
- Судалгаа хөгжлийн ажлын үр дүнг жижиг дунд үйлдвэрүүдэд нэвтрүүлэхэд болон эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургуулиудтай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх.
- Дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлсэн, нутагшуулсан жижиг дунд үйлдвэрүүдийн судалгаа хөгжлийн ажилд зарцуулсан зардлын тодорхой хувийг нөхөн олгох боломжийг бүрдүүлэх.
- Эрдэм шинжилгээний байгууллагуудын үйл ажиллагааны чиглэлийг холбогдох байгууллагуудтай хамтран салбарын бодлого зорилттой уялдуулан шинэчлэн тодорхойлох.
- Эрдэм шинжилгээний байгууллагуудын удирдлага, бүтэц зохион байгуулалт, харьяаллыг боловсронгуй болгох чиглэлээр асуудал боловсруулж холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх.
- Эрдэмтэн судлаачдын хүрээг өргөжүүлэх, судалгаа хөгжлийн ажлын багтаамж, агуулгыг гүнзгийрүүлэх чиглэлээр арга хэмжээ авах.
- Эрдэм шинжилгээний байгууллагуудын судалгааны материаллаг бааз /лабораторийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж/ -ыг бэхжүүлэх, хангамжийг сайжруулах.
- Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөтгөх бэхжүүлэх, идэвхжүүлэх